

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 25

Орхон аймаг

Нэг. Захиргаа, хяналтын хэлтсийн танилцуулга

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаалаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын бүтэц орон тоо, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ны А/31 тоот тушаалаар Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь Захиргаа, хяналтын хэлтэс болж 12 орон тоотойгоор батлагдсанаас Хяналт шалгалтын улсын байцаагч 2, Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч 1 болж нийт 3 хяналтын байцаагч Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Захиргаа, хяналтын хэлтсийн албан хаагч, ажилчид нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн комисс, өмч хамгаалах комисс, төсөл хөтөлбөр инновацын бүтээмжийн баг, нэгдсэн стандарт хэрэгжүүлэлтийн баг, эцэг эхийн зөвлөл, маргаан хянан шийдвэрлэх зөвлөл зэрэг газрын дэргэдэх 6 орон тооны бус комисс болон зөвлөлд ажиллаж байна.

Хоёр. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд:

Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг ханган Нийгмийн даатгалын сангаас олгогдож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн бодолт тогтоолт, хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа болон оношийг магадалж хянан шалгах агаас гадна аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс ирүүлсэн албан тоот, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх хүртэл хугацаанд:

1.1 Шинээр тэтгэвэр тогтоолгон авч байгаа 488 тэтгэвэр тогтоолтыг тухай бүр хянан шалгаж ажилласан. Шинээр тогтоогдсон тэтгэврээс 152 зөрчил дутагдлыг илрүүлж тухай бүр нь засуулж, тэтгэвэр авагч нарт нэмж олгохоор 1,298.7 мянган төгрөг, хасаж олгохоор 592.9 мянган төгрөгийг шийдвэрлэж ажилласан.

1.2 Тэтгэмжийн 2 байцаагч, үйлчилгээний хэсгийн 1 байцаагчийн бодсон тэтгэмж олгох анхан шатны баримтыг хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 4 байцаагч хяналт тавьж тэтгэмжийн даатгалын сангаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан нийт 1392 даатгуулагчид олгохоор тооцсон 3,052.07 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж 142 удаагийн зөрчлийг тухай бүр залруулах арга хэмжээ авч ажилласан.

- Хөдөлмөрийн чадварын түр алдсаны тэтгэмжийг 712 даатгуулагчдад 752.07 сая төгрөгийн тэтгэмжийн бодолтод хяналт тавьж ажилласан байна.
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 680 даатгуулагчдад 2,3 тэрбум төгрөгийн тэтгэмжийн бодолтод хяналт тавьж ажилласан байна.

1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгохоор тооцсон сувиллын газрын тусламж үйлчилгээний болон ирэх, очих унааны зардлыг нийт 11 даатгуулагчийн зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж ажилласан байна.

1.4 Ажилгүйдлийн даатгалын сангаас тогтоогдон олгогдож байгаа ажилгүйдлийн 490 хүний тэтгэмжид хяналт тавьж 85 зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж, эрх үүсэхгүй 5 хүний 15.3 сая төгрөгийг олгохгүйгээр шийдвэрлэж ажилласан.

1.5 Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 75 албан тоот, хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу зөрчлийг барагдуулан ажилласан байна.

- Улсын байцаагчийн акт – 26
- Улсын байцаагчийн дүгнэлтээр цалин залруулга – 22
- Улсын байцаагчийн дүгнэлтээр төрөл залруулга – 27

1.6 Иргэнээс ирсэн 41 өргөдлийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

- Улсын байцаагчийн акт – 5
- Тэтгэвэр тогтоолтын үндэслэл дахин шалгах – 32
- Бусад – 4
-

1.7 Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/1107 тоот албан тоотын дагуу 2024 оны 01-05 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмжийн олголтод хийсэн дотоодын шалгалтаар илэрсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдал:

- ❖ Нийт тэтгэврийн сангаас 36 даатгуулагчид илүү шилжүүлсэн 11,058,096.00 төгрөгийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, Тэтгэвэр авагч Х.Байгалмаа (ФЖ70040507)-ийн тэтгэврээс шүүхийн шийдвэрээр 50% суутгал хийхдээ 2024 оны 04-06 саруудад нэмэгдсэн 100,000.00 төгрөгийн 50% болох 50,000.00 төгрөгийг дутуу шилжүүлсэн зөрчлийг 7 дугаар сард нөхөн шилжүүлэн зөрчлөө 100% арилгасан.
- ❖ 2024 оны 01-05 дугаар саруудад нийт олгосон 1393 даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж 3,113,932,065.00 төгрөг олгосноос илүү шилжүүлсэн 12 даатгуулагчийн 4,551,141.00 төгрөгөөс 3,113,992.00 төгрөг буюу 68.42% барагдуулсан.

1.8 Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 08/2075 тоот албан бичгийн дагуу SICOS системд 2024 оны 06-10 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмжийн олголтод дотоодын шалгалтаар илэрсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдал:

- ❖ 2024 оны 06-10 дугаар саруудад нийт олгосон 18847 даатгуулагчид 87,622,698,966.54 төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас олгосноос 22,725,168.00 төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас илүү шилжүүлсэн дүнгээс 8,481,322.00 төгрөгийг, дутуу шилжүүлсэн дүнгээс 3,995,402.00 төгрөгийг тус тус барагдуулсан.
- ❖ 2024 оны 06-10 дугаар саруудад нийт олгосон 2744 даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж 1,610,035,899.00 төгрөг, 837 даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмж 2,936,676,225.00 төгрөг олгосноос 30,424,555.00 төгрөгийг тэтгэмжийн сангаас илүү шилжүүлсэн дүнгээс шалгалтын явцад 21,950,731.00 төгрөг буюу 72.15% -ийг барагдуулсан.

2. Нийгмийн даатгалын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, бусад ажлын хүрээнд:

2.1 Улсын байцаагчийн актын 2024 оны эхний үлдэгдэл 10.31 сая төгрөг байснаас эхний хагас жилд 6.01 сая төгрөг болгон 41.7% буурсан. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлт, иргэдийн өргөдлийн дагуу нийт 106 байгууллагын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж, цалин болон төрлийн залруулгын дүгнэлт бичиж, ААНБ-ын санхүүгийн баримт, НД-ын сангийн зарцуулалтад хяналт шалгалт, дотоод аудит хийж 47 зөрчилд улсын байцаагчийн акт болон зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 30.5 сая төгрөгийн шимтгэл, 7.1 сая төгрөгийн алдангийг төвлөрүүлэн ажилласан. Үүнээс зөрчлийн тухай хуулиар 34 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой зөрчлийг шийдвэрлэхдээ 4 зөрчлийг татгалзаж, 5 зөрчлийг шийтгэлээс чөлөөлж, 25 зөрчилд 7.05 сая төгрөгийн торгуулийг тавьж 100 хувь бүрэн барагдуулан ажилласан.

2.2 2024 оны 04 дүгээр сарын 18 өдрийн 06/809 тоот ЗХ-ний жанжин штабын дарга, НДЕГ-ын даргын хамтарсан тушаалын дагуу ЗХ-ний 210 дугаар ангид 1995-1997 он хооронд алба хаасан 702 цэргийн албан хаагчийн овог нэр, регистрийн дугаарыг бүрдүүлэх ажлын хүрээнд 670 цэргийн албан хаагчийн мэдээллийг бүрдүүлэн жагсаалтыг хуваарийн дагуу хугацаанд нь хүргүүлж х ажиллаж байна.

2.3 ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг 2021 оны 5 хавтас, 2022 оны 5 хавтас, 2023 оны 6 хавтас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн 390 хувийн хэрэг, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 35 хувийн хэрэг, 2021-2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 2 хавтас, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан зэрэг анхан шатны баримтад тулгуурлан шалгаж, 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийн төрлийг хэвийнээс ҮОМШӨ болгож залруулахыг үйлчилгээний тасгийн даргад даалгаж, 1 тэтгэвэр авагчийн үйлдвэрлэлийн ослын акт байхгүй байсныг илрүүлж иргэнээс нь авч хувийн хэрэгт хавсарган илэрсэн 2,05 сая төгрөгийн төлбөрийн зөрчлийг 100 хувь барагдуулж ажилласан.

2.4 Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн болон олон улсын нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын хэрэгжилтийн үнэлгээ хийсэн.

✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийн үнэлгээ:

№	MNS 5140-2:2021	Заалт	Нийт дүн	Тайлбар
1	Тохирох	5.1-5.17, 5.19-5.20, 5.23-5:28	25	Байгууллага баримт бичиг боловсруулахдаа стандартын заалтыг мөрдөн ажиллаж байна.
2	Үл тохирох	5.21, 5.22	2	Шийдвэрлэсэн баримт бичгийг хөтлөх хэрэгт хадгалсан тухай тэмдэглэл болон баримт бичгийн үлдэх хувь дээр хадгалсан файлын нэрийг бичдэггүй үл тохирол гарсан.

№	MNS 5140-3:2021	Заалт	Нийт дүн	Тайлбар
1	Тохирох	3.1-3.11, 3.13-3.20	19	Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрийн бүрдлийг байрлуулахад тавих стандартын шаардлагыг мөрдөн ажиллаж байна.

- ✓ Iso стандартын хэрэгжилтийн аудитын үр дүн ба тэргүүлэх аудиторовн үнэлгээ:

Давуу тал	Сайжруулалтын боломж	Анхаарах хэсэг		Жижиг үл тохирол		Том үл тохирол	
		Өмнөх жилийн аудит	Энэ удаагийн аудит	Өмнөх жилийн аудит	Энэ удаагийн аудит	Өмнөх жилийн аудит	Энэ удаагийн аудит
2	9	5	3	3	2	0	0

2.5 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн 159 болон байгууллагын 171 шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан нийт 133 мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгаж үнэн зөв байршуулж, хэрэглэгч, ажил олгогч, иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжийг бүрдүүлж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ✓ Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 78 ба мэдээлээгүй 18 байна.

Тайлан үүсгэх, тохируулах / Байгууллагын хэрэглэгчийн оруулах мэдээлэл

Хэрэглэгчийн мэдээллийн хяналт

Нийт мэдээлэх	159	Хугацаандаа Мэдээллэсэн	140	Хугацаа хоцорч мэдээллэсэн	1	Мэдээлээгүй	18
---------------	-----	-------------------------	-----	----------------------------	---	-------------	----

Засгийн газар, орон нутгийн тусгай сан

Тайлант он: 2024

Тэмдэглэгээний тайлбар

- ✓ Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 85 ба мэдээлээгүй 86 байна.

Тайлан үүсгэх, тохируулах / Байгууллагын хэрэглэгчийн оруулах мэдээлэл

Хэрэглэгчийн мэдээллийн хяналт


Нийт мэдээлэх	171	Хугацаандаа Мэдээллэсэн	152	Хугацаа хоцорч мэдээллэсэн	0	Мэдээлээгүй	19
---------------	-----	-------------------------	-----	----------------------------	---	-------------	----

Төсвийн байгууллага

Тайлант он: 2024

Тэмдэглэгээний тайлбар

2.6 Цахим хуудсанд бүрэн оруулаагүй дутуу оруулсан 8.2.8, 8.2.9, 8.3.1 мэдээллийг бүрэн оруулж, шинэчлээгүй байсан 8.2.2, 8.2.6, 8.3.2, 8.3.3, 8.3.4, 8.3.6, 8.5.1 мэдээллийг шинэчлэн оруулж байгууллагын нээлттэй 48 мэдээллийг бүрэн оруулж, мэдээллийн самбарт байршуулан ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг ханган ажилласан.



3. Сургалт сурталчилгааны ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд 10 аж ахуй нэгж байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хуулийн шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэн ажилласан. Мөн газрын нийт байцаагч ажилтан нарт 6 удаагийн сургалт орж мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллага, холбогдох байгууллагуудын албан хаагч, мэргэжилтнүүдтэй холбогдож ойлголтын зөрүүг арилгаж, шаардлагатай тохиолдолд сургалт, зөвлөгөө, мэдээлэл авч ажиллаа.

